



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар A/68

Хөхөө

Тамхины тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, 7.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс Тус сумын Хөхөө (4-р) багийн Хөвөн хороололд байрлах “Хоёр-Эрдэнэ” хүнсний дэлгүүр нь Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас 500 метрийн зайтай тул тамхины 00015 дугаартай тусгай зөвшөөрлийг сунгахыг зөвшөөрсүгэй.

2.Тусгай зөвшөөрлийн сунгалтын үнэ болох 100,000(нэг зуун мянган) төгрөгийг Орон нутгийн орлогын 171900941 тоот дансанд оруулахыг “Хоёр-Эрдэнэ” дэлгүүрийн эзэн (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3.Уг дэлгүүрт Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Өлзийсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ